

ШАШНЫ ТУХАЙ ХОЖУУ ҮЕИЙН ПСИХОАНАЛИТИК ОНОЛЫН БАЙР СУУРЬ

С.Соёлмаа - ШУА, ФСЭЗХ. Философийн секторын ЭША, докторант

Түлхүүр үг: Хүмүүнлэг ба авторитари шашин, үйлдэл сэтгэлгээний тогтолцоо, сэтгэц задлан шинжлэл, хайрлах мэдрэмж, рациональ ба рациональ бус зан үйл.

Товч агуулга: Орчин үеийн хүнд шашинд хандах хандлага, түүнийг үнэлэх үнэлэмжийн асуудал тулгараад байгаа тухай, мөн үүнийг хэрхэн даван туулах, шийдвэрлэх тухай хожуу үеийн психоаналитикч Э.Фроммын үзэл, байр суурийг тайлбарласан болно. Ингэхдээ XX зууны зарим нэг шашны философийн төлөөлөгч нарын үзлийг Э.Фроммын үзэлтэй харьцуулан авч үзсэн.

Шашны асуудал, цаашилбал сүсэг бишрэл, итгэл үнэмшлийн асуудал өнөөгийн нийгэмд тулгамдаад байгаа асуудал билээ. Шашинд өөрт нь асуудал байна уу, эсвэл шашинд хандах хүнд нь асуудал байна уу гэдэг нь маш чухал асуулт юм. Монголын нийгэмд төдийгүй хүн төрөлхтний хэмжээнд шашны ухамсар, сүсэг бишрэлийн асуудал хурцаар тавигдаад байгаа билээ. Шашны олон янз байдал нь соёл хоорондын мөргөлдөөнийг бий болгох аюулыг өөртөө дагуулдаг бол харин шашны нэгдэн нийлэх үзэгдэл нь олон соёлыг устах аюулд хүргэдэг учир шашны хэтийн төлөв нь шинжлэх ухааны зайлшгүй том асуудал юм. Тийм ч учраас шашныг орчин үеийн шинжлэх ухааны онолын байр сууринаас нухацтай судлах зайлшгүй шаардлага шашин судлалын өмнө төдийгүй, бусад олон шинжлэх ухааны өмнө тавигдаж байна. Шашны сэтгэл зүй (З.Фрейд, Эрих Фромм), шашны социологи (Макс Вебер, Бронислав Малиновский, Эмиль Дюркгейм, Карл Маркс), шашны түүх судлал (Макс Мюллер), шашны философи гэх мэт шинжлэх ухааны олон салбар шашны мөн чанар, үүсэл гарал, хөгжил, хүний нийгэм, оршихуйд шашны эзлэх байр суурь, хэтийн хөгжлийн талаар судалж шашин судлалын шинжлэх ухаанд хувь нэмрээ оруулдаг. Шашин хэмээх нь маш өргөн ойлголт учир архелог, соёл судлал, хэл шинжлэл, угсаатан судлал, антроплогийн шинжлэх ухаанд ч байр сууриа эзэлдэг.

Энэ өгүүлэлдээ XX зууны герман-америкийн философич, психоаналитикч, неофрейдизмыг үндэслэгч Эрих Фроммын шашны тухай хожуу үеийн сэтгэц задаргааны онолын гол үзэл санааг товчхон сийрүүлэх зорилго тавьлаа.

Эрих Фроммын үзлээр гол асуудал хүн шашин, бурханд итгэх итгэл рүүгээ эргэж очих эсэхэд бус, харин хүн үнэнээр сэтгэж, хайраар амьдарч чадаж байна уу гэдэг нь л чухал. Сонгодог сэтгэл судлал өөрийн гол судлагдахуун болох сэтгэлийг гэсэн бөгөөд сэтгэл хөөрөл хэрхэн явагдах механизм, хүний төрөлх занг л судалсаар ирсэн билээ. Харин хүний онцгой үзэгдлүүд болох хайр, оюун ухаан, зөн совин, үнэт зүйлсийг сонгодог сэтгэл зүй мартсан гэж хэлэхэд болно. Сэтгэц задаргааны онолын байр сууринаас техник технологи, шинжлэх ухааны хөгжилд хүн хүрч чадсан боловч сэтгэлийн сайн сайхан, тайван байдалд хүрч чадаагүй. З.Фрейдын үзлээр шашин гэдэг бол хүүхдийн туршлагыг давтан дагаж мөрдөхтэй адил бөгөөд хүний бурхны тухай

үзэл санаа нь хүний хүсэл дээр тулгуурласан хуурамч байдлаас эхлэлтэй. Мөн тэрээр шашин бол ёс суртахууны хамгийн тогтворгүй үндэс юм. Ёс зүй, шашин хоёрын нэгдэл нь бидний ёс суртахууны үнэт зүйлийг устахад хүргэнэ. Шашин бидний үнэт зүйл, төгс төгөлдөрийг үгүй болгодог. Бидний үнэт зүйл, төгс төгөлдөр бол хайр, үнэн, эрх чөлөө юм. Хүн хайр энэрэлээ өгдөг эцэг бурхан хэмээх мэдрэмжээ орхиж бодит байдалтай зохицон амьдарч сурах хэрэгтэй. Хүн ямар нэг өөр зүйлд найдахын оронд өөрийн хүч чадалд найдаж сурах хэрэгтэй, хэрэв ингэж чадах юм бол тэр өөрийн хүч чадлыг зөв ашиглаж сурна. Зөвхөн эрх чөлөөтэй хүн л өөрийн боломжийг харж, худал хуурмагт автахгүйгээр, бодит байдалд объектив байдлаар хандаж, хорвоо ертөнц дэхь өөрийн байр сууриа зөв тодорхойлж, оюун ухаанаа зөв ашиглаж чадна гэх зэргээр Фрейд хүний шашны ухамсарт нэлээд шүүмжлэлтэй хандсан байдаг. Түүний үзэж байгаагаар ганцаардлын мэдрэмж нь шашны мэдрэмжийн эсрэг ойлголт юм. Харин К.Г.Юнг шашны мөн чанарыг дээд хүчийг буруутгахад оршдог гэсэн байна. Түүний үзлээр шашин бол хүсэл зоргоор өдөөгдөөгүй тийм үйлдэл, оршихуйн сайтар болгоомжтой ажиглалт юм. Шашин хүний субъектыг эзлэн авч түүнийг удирддаг, харин хүн үргэлж түүний золиос нь болдог. Шашны туршлагыг гадаад хүчний илэрхийлэл хэмээн үзээд, харин далд ухамсарыг шашны ойлголт гэж үзэн үүнийгээ дэлгэрүүлэн тайлбарлажээ. Далд ухамсар бол хувь хүний ухамсарын энгийн нэг бүрдэл хэсэг бус, бидний ухамсарт шингэсэн хянаж болшгүй тийм хүч юм.

3. Фрейдын үзлээр хүний хөгжлийн зорилго бол мэдлэг, үнэн, эрх чөлөө гэх мэт чин эрмэлзэлд тэмүүлж, хараат бус байдалд хүрэх бөгөөд эдгээр чин эрмэлзэл нь дэлхийн бүхий л шашны ёс суртахууны үндэс болдог байна. Дорнын болон өрнийн соёл дахь Конфуци, Лао-цзы, Будда, Иисусын сургаал нь эдгээр чин эрмэлзэл дээр тулгуурласан байдаг. Гэхдээ мэдээж эдгээр шашны сургаалиуд нь яг юун дээр гол анхаарлаа төвлөрүүлж байгаагаараа ялгаатай байдаг. Тухайлбал, Будда хүний зовлонг хөнгөвчлөх дээр анхаарлаа хандуулдаг бол сургаал хайрлагчид (пророки) мэдлэг, шударга байдалд анхаарлаа хандуулаг. Харин Иисус ах дүүсийн хайр дээр анхаарлаа хандуулдаг байна. Фрейд шашны ёс суртахууны үндсийг хамгаалж, харин ёс суртахууны зорилгыг хэрэгжүүлэхэд саад болж буй бурхан, дээд хүчний талыг шүүмжилсэн юм. Фрейд бол шашныг үгүйсгэсэн бус, харин бурханд хандах хүмүүсийн хандлагыг шүүмжилдэг.

Юнгийн үзлээр шашны туршлага нь сэтгэл хөдлөлийн онцгой төрөл юм. Энэхүү онцгой төрөл бол бурхан эсвэл далд ухамсар болох тийм далдын хүчинд харъяалагдах явдал юм. Гэхдээ энэ нь мэдээж христосын шашинд илүү тодорхой харагдах боловч буддын шашинд арай өөр байх талтай юм гэж Э.Фромм үзжээ. "Шашны сэтгэл зүй" хэмээх Юнгийн байр суурь нь Уильям Жеймстэй нэлээд төстөй бөгөөд харин Фрейдын байр суурь нь Жон Дьюигийн байр суурьтай төсөөтөй байдаг. Джеймс шашны хандлагыг нэгэн зэрэг золиос

ба арчаагүй байдал гэсэн бөгөөд энэ байр сууринаас хүн бурхны гэх зүйлд холбогдсон мэт санах хэрэгтэй болдог байна. Юнгийн адилаар Жеймс далд ухамсарыг бурхны теологи хандлагаар тайлбарласан байна. Тухайлбал, тэрээр үзэхдээ далд ухамсарыг бурханы теологи ойлголттой харьцуулан “шашны хүн гадаад хүчээр үйлддэг гэсэн бурханы сургаалтай адилаар далд ухамсарын нэг онцлог нь объектив дүр зургийг хүлээн авч субъектэд гадаад хүч мэтээр дүрслэгддэг”. Тэрээр далд ухамсар болон бурханы хооронд сэтгэл зүйн болон шашны нэгдлийг олж харсан. Жон Дьюигийн үзлээр шашин болон шашны туршлага нь хоорондоо ялгаатай ойлголт болдог. Түүний хувьд дээд хүчний тухай сургаал нь хүний шашны хандлагыг сулруулдаг. “Шашин ба шашны үнэлэмж хоорондын зөрчлийг арилгах боломжгүй. Энэхүү үнэт зүйлс нь маш чухал учраас түүнийг итгэл үнэмшилтэй бүрэн адилтгаж болохгүй” (Dewey J. A Common Faith. Yale University Press, 1934, p. 28) гэсэн байна. Фрейдын адилаар Дьюи “хүн хэзээ ч амьдралын сайн сайханд хүрэхийн тулд өөрийн хүч чадлаа бүрэн ашиглаж байгаагүй. Учир нь тэд ямагт ямар нэг гадаад хүчинд итгэж найдсан бөгөөд энэхүү гадаад хүч нь өөрийнх нь хариуцах ёстой зүйлийг хийнэ гэж итгэдэг” » (ioc. cit., p. 46) гэсэн байна.

Харин Э.Фромм шашныг “хүнд утга учиртай амьдрах боломжийг олгодог, мөн үүний зэрэгцээ шударга амьдрах зүйлийг өгч чаддаг тийм үйлдэл, сэтгэлгээний дурын тогтолцоо/1” гэж үзжээ. Түүний үзлээр яг үнэндээ бол шашин ийм өргөн утгаараа ойлгогддог тийм соёл оршиж ч байгаагүй, орших ч боломжгүй.

Фромм хүний бурханд хандах хандлагыг гол шалгуур болгон шашныг хоёр ангилан үзжээ. Үүнд, авторитар ба хүмүүнлэг шашин багтана. Оксфордын толь бичигт авторитари шашныг тодорхойлохдоо «шашин бол хүнээс дуулгавартай байдал, хүндлэл, залбирлыг шаарддаг, хүний хувь заяаг удирддаг үл үзэгдэх дээд хүчийг хүн өөрөө хүлээн зөвшөөрөх явдал юм» гэсэн байна. Чухам ямар учраас энэ нь авторитари шашны тодорхойлолт болж байна вэ гэхээр энд хайр, шударга байдал гэх мэт хүний ёс суртахууны зан чанарыг бус, харин дээд хүчинд хамаарах харъяаллыг гол шалгуур болгожээ. Түүний тодорхойлсноор хүнээс гадна орших тийм хүчийг хүлээн зөвшөөрдөг шашныг авторитари шашин гэнэ. Шашны ийм хэв маягийн гол сайн сайхан нь дуулгавартай сонсох байдал байдаг бол дуулгаваргүй байх нь хамгийн том нүгэл юм. Харин хүмүүнлэг шашин бол хүн болон түүний хүч чадлыг төв байр сууринд тавьдаг. Хүн ертөнцөд эзлэх байр сууриа, бусдад хандах хандлагаа, өөрийгөө ойлгохын тулд оюун ухаанаа хөгжүүлэх ёстой гэж хүмүүнлэг шашин үздэг. Хүн өөрийн хязгаартаа, өөрийн боломжоороо үнэнд хүрч чадах ёстой. Ийм хэв маягийн шашин дахь шашны туршлага нь хүний санаа сэтгэл, хайрын тусламжтайгаар ертөнцтөй мөн чанараараа холбогдох нэгдмэл байдлыг мэдэрч ойлгохуй болдог. Хүмүүнлэг шашинд хүний цорын ганц зорилгыг хүчгүйдэлд бус, харин агуу хүч чадалд хүрэх гэж үздэг. Сайн үйл бол өөрийн хүч чадлыг сорих явдал бөгөөд дуулгавартай байдал бус. Итгэл үнэмшил нь

бодлогогүйгээр бусдын санааг хуулбарлах бус, харин санаа болон мэдрэмжийн туршлага дээр үндэслэдэг. Хэрэв хүмүүнлэг шашин нь бурханлаг бол энэхүү бурхан нь хүний өөрийнх нь хүч чадлын бэлгэ тэмдэг байх болно. Ийм хэв маягийн шашны тоонд буддизм, даосизм, Спиноза, Сократ, Иисус, Исайин сургаал, мөн Еврей болон Христос шашны зарим нэг чиглэл, ялангуяа мистицизм, Францын хувьсгал дахь Оюун ухааны шашин зэрэг багтана.

Хүмүүндэг шашны хамгийн шилдэг жишээ бол Буддизмын түрүү үеийн сургаал бөгөөд Будда бол хүний оршихуйн утга учир дахь үнэнд хүрч чадсан, "сэрж чадсан" агуу багш юм. Тэрээр ямар нэг дээд хүчний өмнөөс сургаал номлоогүй, харин оюун ухааны өмнөөс хүмүүст хандсан бөгөөд хүнийг өөрийн оюун ухааныг ашиглаж үнэнийг таньж мэдэхийг уриалжээ. Бүрэн хэмжээгээр гэгээрсэн ухамсар болох Нирваны тухай сургаал нь ямар нэг арчаагүй байдал, хүнийг буруутгасан тухай сургаал бус, харин хүний дээд хүч чадлыг хөгжүүлэх тухай сургаал юм.

Буддагийн тухай нэгэн түүхэнд энэ нь тод харагдаж байдаг.

Жимсний модон доор нэгэн туулай сэржээ. Гэнэт тэр маш аймшигтай дуу сонссон байна. Дэлхий сөнөх гэж байна гэж бодоод зугтахаар шийджээ. Бусад туулай нөгөөх туулайг хараад яагаад ингэж хурдан гүйж байгааг нь асуухад "Ертөнцийн төгсгөл ирж байна" гэж хэлжээ. Ингээд бусад туулайнууд ч хойноос нь гүйсэн байна. Буга, тэдгээр туулайг хараад яагаад ингэж зугтаж байгааг нь асуухад "Ертөнцийн төгсгөл ирэх гэж байгаа учир бид зугтаж байна" гэж хариулжээ. Ингээд тэдэнтэй буга нийлжээ. Ингээд бүх амьтад ар араасаа нийлцгээж гэнэ. Хэрэв тэднийг Будда хараагүй бол тэд тэр чигээрээ гүйсээр байгаад цуцаж үхэх аюулд өртөх байлаа. Энэ үед мэргэн Будда тэднийг харж, хамгийн сүүлийн амьтнаас нь яагаад бүгдээрээ гүйгээд байгааг асууж гэнэ. Яагаад гэвэл ертөнцийн төгсгөл ирэх гэж байна гэж амьтад хариулжээ. "Ертөнцийн төгсгөл ирэх гээгүй байна. Яагаад амьтад ингэж бодсоныг олж мэдье" гэж Будда хэлсэн байна. Ингээд бүх амьтнаас асуусаар хамгийн сүүлд туулайнууд дээр ирж энэ тухай асуухад анхны зугтсан туулайг заан өгчээ. Будда энэ туулайнаас "Чи дэлхий сөнөх гэж байгаа тухай мэдэхдээ яг хаана байсан бэ?" гэж асуужээ. Туулай "Би жимсний модон доор унтаж байсан" гэжээ. "Жимсний модноос жимс унаж чамайг чочооход чи айснаасаа болж дэлхий сөнөх гэж байна гэж бодсон байх. Явж үнэн эсэхийг шалгая" гэж Будда хэлжээ. Ингээд модны доор очиход үнэхээр тийм байжээ. Ийнхүү Будда амьтны аймгийг аварсан байна.

Дээрх жишээ нь зөвхөн буддизмын амьтныг хайрлах энэрэх сэтгэл бус, хүний хүч чадалд итгэх итгэл, ертөнцийг оюун ухаанаар ойлгох ойлголтыг онцолсон нь харагдаж байна хэмээн Фромм дүгнэжээ.

Хүмүүнлэг шашны тогтолцооны нэгэн өөр хувилбар бол Спинозагийн шашны пантейст⁴⁷ үзэл санаа юм. Бурхан ертөнцийг өөр байдлаар бүтээж чадахааргүй байсан. Тэр юуг ч өөрчилж чадахгүй. Тэр орчлон ертөнцтэй бүхэлд нь тэнцүү. Хүн өөрийн хязгаар боломжоо харж, өөрийн дээр байгаа хүчний нөлөөллийг ухамсарлах ёстой ч гэсэн түүнд оюун ухаан, хайрлах чадвар байдаг юм. Тэр оюун ухаан, хайрлах чадвараа хөгжүүлж чадах бөгөөд дотоод хүч, эрх чөлөөнд хүрч чадна гэж Спиноза үздэг.

Э.Фромм Христосын шашны гол номлол болох Библи нь хүмүүнлэг болон авторитари шашны аль альных нь шинжийг агуулсан байдаг гэжээ.

Түрүү үеийн христосын шашин илүү хүмүүнлэг шинжтэйг Э.Фромм онцолжээ. Энэ нь Иисусын хэлж буй үгнээс харагддаг ба Иисусын нэгэн сургаальд "...бурхны хаанчлал таны дотор байгаа..." гэсэн байдаг. Энэ нь хүмүүнлэг үзэл санааны маш энгийн бөгөөд ойлгомжтой жишээ юм. Харин хэдэн зуун жилийн дараа Христос шашин нь Ромын эзэнт гүрний шашин болсноос хойш авторитари хандлагатай болсон юм. Гэсэн хэдий ч Фроммын үзлээр Христосын шашин хэзээ ч хүмүүнлэг утгаа алдаж байгаагүй.

Э.Фромм сэтгэц задаргааны онолын үүднээс шашин хэмээх ойлголтыг тайлбарлахдаа сэтгэц задаргааны онолын нэг чухал нээлт бол оюун санааны зөв байх шинжид задлан шинжилгээ хийсэн явдал юм гэж үзжээ. Уламжлалт ойлголтоор бол хүний ухамсар нь өөрийнхөө тухай санасан санаа юм. Мөн хүн эх орноо хайрлах хайр, шударга ёсонд тэмүүлснээрээ дайн хийдэг, эцэг эх үр хүүхдээ үүрэг хариуцлагын мэдрэмжээрээ шийтгэдэг, шударга бус хүмүүсийг бурхны нэрийн өмнөөс шийтгэдэг гэх мэтээр тайлбарлаж байлаа. Харин хүний сэтгэлгээний шинэ хандлага анх Спинозагийн «Петрийн тухай Павлын яриа нь бидэнд Петрээс илүү Павлын тухай өгүүлдэг» гэсэн илэрхийлэлд харагддаг. Үүнд Петрийн ярьсан үнэнг биш, харин Павлын Петр хандаж буй хандлагыг илүү чухалчилж байгаа хэрэг. Спинозагийн энэ санаанд Фрейдын хүний тухай онолын байр суурь харагдаж байгаа юм.

Сэтгэц задаргааны эмчилгээний гол зорилго бол нэг талаас, өвчтөнийг зохицоход сургах байдаг бол нөгөө талаас, түүний зорилго нь хувь хүний чадварыг зөв хөгжүүлж, хэрэгжүүлэх бөгөөд энэ утгаараа сэтгэц задлан шинжээчийг "сэтгэл эмчлэгч" хэмээн Фромм үзжээ. Хэрэв хэн нэгэн өөрийн ёс суртахууны болон оюун ухааны зорилготой байдлыг зөрчвөл өөрийгөө устгаж, аз жаргалгүй болж, зовох болдог. Хэрэв соёл түүний амьдрах энэ арга барилыг зөвшөөрөх юм бол ийм зовлонг хүн мэдрэхгүй өнгөрүүлнэ. Гэсэн хэдий ч сэтгэлийн эрүүл мэнд нь хүний хайрлах чадвар, хайрын бүрэн чанар, хайрын бие даасан байдлаас шалтгаалдаг.

Э.Фроммын үзлээр "зохицсон хүн" нь өөрийгөө бараа товар мэт үздэг ба

- таашаал авах, хэрэгтэй үед үүргээ солих шаардлагаас өөр ямар ч тогтвортой,

⁴⁷ ПАНТЕИЗМ (от греч. πᾶν - бүх и θεός - Бурхан) - бурхныг ертөнцтэй дотоод чанаараа тэнцүү буюу бурхан ертөнц хоёрыг агаар нэг хэмээн үздэг шашин- философиин үзэл, сургаал юм /9/.

тодорхой үнэлэмжтэй байдаггүй. Хүн амжилттай байдал руу тэмүүлэх үедээ алдах тохиолдолд сэтгэлийн дотоод хоосон байдал руу орчихдог байна. Энэ байдал үргэлжилж хүссэн хүсээгүй түүний бие мах бодь өвчлөхөд хүрдэг байна. Хэдийгээр гадаад байдалдаа тийм ч амжилттай бус мэт харагдах боловч өөрийн дотоод хүч, бүрэн чанартаа хүрч чадсан хүн бодит байдлыг бодьтойгоор дүгнэх, шүүх чадвартай, илүү өөртөө итгэлтэй байдаг. Ийм байдлаар сэтгэлийг эмчлэх үүргээрээ сэтгэц задлан шинжээч шашны үүргийг биелүүлж байна/2/.

Сэтгэц задлан шинжлэх эмчилгээний зорилго нь амьдралд хандах шашны хандлагад хүрэхэд нь хүнд туслах явдал юм. Үнэнийг хүлээн зөвшөөрөх нь сэтгэц задлан шинжлэх үйл явцын гол зорилго болдог. Сэтгэц задлан шинжлэл нь үнэний тухай ойлголтонд шинэ хэмжүүр өгсөн юм. Аналитик сэтгэлгээнээс өмнөх хандлагад хэрэв хүн өөрийнхөө үгэнд итгэж л байвал үнэнийг ярьдаг гэж үздэг бол сэтгэц задлан шинжээч субъектив итгэл үнэмшил нь чин үнэнч сэтгэлийн шалгуур болохгүй гэж үздэг. Хүн шударга ёсны мэдрэмжээрээ үйлдэж байна гэж итгэж болно, гэвч түүний гол түлхэгч хүч нь хатуу сэтгэл байж болох юм. Хүн ойр дотны хүнтэй ямар нэг дотны харилцаанд орох шалгуураа хайр гэж үзэж болох юм, гэвч түүний гол түлхэгч хүч нь хайр биш эзэмших, эзлэх хүсэл байж болох юм. Хүн өөрийн оюунлаг байдалдаа хүмүүсийг итгүүлэхийг хүсдэг төдийгүй, мөн өөрөө үүндээ итгэдэг байна. Тэр жинхэнэ түлхэгч хүчээ илүү их ухамсарлах тусам түүндээ гүнзгий итгэдэг. Сэтгэц задлан шинжлэлийн үйл явц нь өөрөө үнэний эрэл хайгуул болдог. Энэхүү эрэл хайгуулын зорилго нь гадаад бус, харин дотоод феномены⁴⁸ тухай үнэнийг олох байдаг. Сэтгэц задаргааны онолын гол зарчим нь хаана бид сэтгэж байна, хаана бид мэдрэмж дээрээ тулгуурлаж итгэж байна, сэтгэлгээ болон мэдрэмжийн ялгаа юунд оршихыг маш сайн судлахгүйгээр сэтгэл санааны эрүүл мэнд болон аз жаргалд хүн хүрч чадахгүй гэж үздэгт оршино. Хүн өөртөө шүүмжлэлтэй байдлаар хандан дүгнэх, түүний үнэн худлыг ялгах чадвар нь шашны хандлагад гол байр суурь эзэлдэг. Тухайлбал, эртний буддын шашны нэгэн бичигт төөрөгдөлд орох 10 алдааг дурдсан байдаг. Үүнд, 1. Хүслийг итгэл үнэмшил хэмээн бодох; 2. Дасах, дотносох сэтгэлийг бишрэл, сүслэл, нигүүлсэлтэй адилтгах; 3. Сэтгэх үйл явцыг зогсоохыг төгсгөлгүй оюуны тайвшрал хэмээн бодох; 4. Мэдрэхүйн мэдрэмжийг бодит байдлыг танин барихуй (эсвэл ухаарахуй) хэмээн ойлгох; 5. Бодит байдлыг энгийнээр ухаарахуйг бүрэн таньж мэдсэнд тооцох; 6. Шашны сургаалыг номлосон мөртлөө амьдралд хэрэгжүүлэхгүй байгаа нэгнийг үнэхээрийн шүтэн бишрэгч гэж үзэх; 7. Дур хүслийн боолчуудыг бүхий л нөхцөлт байдлаас ангижирч чадсан бясалгагч мастерууд мэтээр үзэх; 8. Өөрийн сонирхолд нийцүүлсэн үйлдлийг бодь сэтгэлтний үйлдэл мэтээр үзэх; 9. Худал хуурмагийг болгоомжтой байдал (хашир зан) мэтээр үзэх; 10. Хууран мэхлэгчдийг мэргэн ухаантан мэтээр үзэх.

⁴⁸ ФЕНОМЕН (греч. φαινόμενον, от φαίνεσθαι - болох, харагдах байдалд байх, мөн санагдах) - мэдрэмжийн эргэцүүлэлд өгөгдсөн үзэгдэл, зүйл гэсэн утгатай үг /9/.

Сэтгэц задлан шинжээчийн гол зорилго нь хүний өөрт байгаа худлыг үнэнээс нь ялгаж өгөхөд оршино. Энэхүү эмчилгээний арга нь “үнэн таныг эрх чөлөөтэй болгоно” гэсэн сэдвийн эмпирик илэрхийлэл болно.

Хүмүүнлэг шашны сэтгэлгээ болон сэтгэц задлан шинжлэлийн онолд үнэнийг эрэлхийлэх хүний чадварыг эрх чөлөө, тусгаар байдалд хүрэхтэй холбон тайлбарладаг. З.Фрейд “Нэгэн хуурмаг байдлын ирээдүй”⁴⁹ хэмээх бүтээлдээ шашин хүний оршихуйн дээд зорилго болох эрх чөлөө, бие даасан байдалд хүрэх боломж олгодоггүй бөгөөд хүнийг хамааралтай болгодог гэж үзжээ. Энд мэдээж авторитари шашны талаар ярьж байна хэмээн Фромм дүгнэжээ. Зөвхөн сэтгэцийн өвчтөн өөрийн дарлалаас ангижрах зорилго тавьдаг юм биш, дундаж “зохицлын” хүн ч ийм байдалд амжилт олж болно. Олон тооны хүмүүс зохицолд орж чаддаг ба учир нь тэд сэтгэцийн өвчтөнөөс хурдан бөгөөд эрт бие даасан байдалд хүрэх зорилго бүхий тэмцэлд бууж өгдөг. Тэд “зохицол”-ын байр сууринаас эрүүл хүмүүс боловч бие даасан байдалд хүрэх хүний зорилгыг хэрэгжүүлэх талаасаа сэтгэцийн өвчтөнөөс илүү өвчилсөн байдаг /3/.

“Дотно хүмүүсээ өөр шигээ хайрла” гэсэн Библийн нэгэн сургаал байна. Сексийн дур хүсэл, ганцаардлыг даван туулах чадваргүй байдал нь маш хүчтэй хайрласаны шинж тэмдэг биш гэж үү. Хүмүүс хайрлах амархан, хайрлуулах хэцүү гэж боддог. Хэрэв зах зээлийн нийгмийн байр сууринаас хандах юм бол биднийг хангалттай сайхан биш (сайхан гэдэг үгийн доор гадаад байдал, хувцас, ухаан, мөнгө, нийгэмд эзлэх байр суурь, ирээдүйтэй байдал зэрэг юу ч орж болно) байгаа учир л хайрлахгүй байна гэж боддог. Гэхдээ хүмүүс хайр гэдэг бол энгийн зүйл биш, чи бусдыг хэр хайрлана төдий чинээ бусад чамайг хайрлана гэдгийг тэр болгон ойлгодоггүй. Хүний хамгийн хэцүү асуудал хайрлах чадвар сул байгаад оршиж байна /4/ хэмээн Фромм үзжээ.

Эрих Фроммын үзлээр хайрын феномен, түүний гажилтыг зөвхөн задлан шинжлэх ярилцлагын тусламжтайгаар л гүнзгий судалж болно. Сэтгэцийн өвчтөй хүн юунд харамсаж байгаа, түүнд ямар өвчний шинж тэмдэг илэрч байгаа бүхэн нь бусад хүмүүст сайн сайхныг хүсэх сэтгэл, бусад хүнийг ойлгох, хүндлэх, хариуцлага, асрах мэдрэмж зэргийг өөртөө агуулдаг хайрлах чадварыг эзэмшээгүйгээс үүсдэг байна. Аналитик эмчилгээ нь өвчтөнд хайрлах чадвараа сэргээн олж авахад туслах оролдлого юм. Хайр гэдэг нь хүндлэл ба хүлээн зөвшөөрөх дээр тулгуурладаг бөгөөд хүн өөрийгөө ч мөн ийм байдлаар мэдрэхгүй бол хайр байх боломжгүй юм. Хүмүүнлэг шашинд бурхныг хайрлах хүний хайрын цаана байгаа бодит байдал нь ямар нэг гомдоллох, буруутгах, дарлах мэдрэмжгүйгээр жинхэнээсээ хайрлах чадварыг ойлгодог. Энэ утгаараа бурхны хайр бол сул байдлын бус, хүчтэй байдлын хайрын бэлгэдэл юм.

- Фромм дээрх тайлбарт сэтгэлийг сэтгэц задлан шинжлэлийн аргаар эмчлэх нь өвчтөнд хүмүүнлэг шашны тогтолцоонд хүрэхэд туслах зорилго

⁴⁹ З.Фрейд. Будущее одной иллюзии // Сумерки богов. М., 1989.

тавьдаг гэсэн гол санааг гаргахыг эрмэлздэг. Сэтгэц задлан шинжээч нь хүнийг зөн совингийн дуу хоолойгоо мэдэрч, хариуцлагатай чөлөөтэй байж, үнэнийг харж, хайрлах чадвараа олж авахад тусалдаг. Фромм шашны болон ёс суртахууны гэсэн хоёр ойлголтыг ялгаж үздэг. Шашны ба ёс суртахууны гэсэн 2 ойлголтын ялгаа нь танин мэдэхүйн онолын асуудал хэдий ч Фромм энд сэтгэц задаргааны онолын үүднээс тайлбар хийхийг оролджээ. Үүнд, шашны туршлагын чухал ойлголт бол ертөнцөд хандах хүний хандлагын тайлагдашгүй нууц, амьдралын ухаарал, гайхах мэдрэмж болно. Мэргэн ухаан нь гайхахаас эхэлнэ гэсэн Сократын үг зөвхөн мэргэн ухаанд хамаарахгүй мөн шашны туршлагад хамаарна. Шашны туршлагын өөр нэг ойлголт нь "туйлын санаа тавихуй". Энэ нь хүслээ биелүүлэх хүсэл тачаалын санаа тавихуй бус, харин хүн амьдралаас тавьж буй даалгавараа биелүүлэх, амьдралын утга учирт туйлын байдлаар санаа тавихуй юм. Санаа тавихуй болон гайхахуйгаас гадна шашны туршлагад нэгдэл гэдэг ойлголт чухал байр суурийг эзэлдэг. Энэ нэгдэл нь зөвхөн хүний өөрөө өөртөйгөө болон бусадтай нэгдэх нэгдэл бус, бүхий л амьдралтай, хорвоо ертөнцтэй нэгдэх нэгдэл юм. Фромм шашны хэмээх ойлголтын хамгийн чухал ойлголтыг гаргаж ирж чадсан юм. Энэ бол амьдралын утга учирт санаа тавихуй нь шашны туршлагын, өөрөөр хэлбэл, шашны ухамсарын салшгүй хэсэг гэсэн үг.

Фромм аливаа шашныг 4 бүрдэл хэсэгт хуваажээ. Үүнд, сэтгэл, шинжлэх ухаан-ид шид, зан үйл, семантик буюу бэлгэ тэмдгэн хэл багтана. Сэтгэлийн гансрал хэмээх нь шашны мэдрэмж юм.

Дорнын болон өрнийн бүхий л томоохон шашны үндэслэгчид амьдралын гол зорилгыг хүн өөрийн сэтгэл санаанд санаа тавьж, оюун ухаан хайрын хүчээ нээх юм гэж үздэг. Сэтгэц задлан шинжээч хүн ч ийм зорилготой байдаг. Аливаа шинжлэх ухаан ч мөн ийм зорилго тавьдаг.

Фромм үзлээр шашны гол аюул нь шинжлэх ухаан бус, харин өдөр дутмын амьдралын туршлага болдог. Хүн өдөр дутмын амьдралдаа дээд үнэт зүйлийн эрэлд гарахаа больсон бөгөөд өөрөө өөрийгөө өөрийнхөө гараар бүтээсэн эдийн засгийн машинд үйлчлэх багаж хэрэгсэл болгон хувиргасан. Тэр зөвхөн ашигтай байдал ба амжилтыг л хүсэх бөгөөд сэтгэлээ хөгжүүлэх, аз жаргалын талаар бодохгүй болжээ. Шашинд учирч буй гол аюул занал нь орчин үеийн хүний "зах зээлийн хандлага" /5/ юм гэж Э.Фромм үзжээ.

Хэрэв хүний дээд үнэт зүйл нь хайр, үнэн, шударга ёс, нинжин сэтгэл бус харин амжилт болсон юм бол түүнд хичнээн ойлгуулж тайлбардласан ч тэр амжилтыг л гол дээд үнэт зүйлээ болгоно. Зах зээлийн хүн бурханд мөргөх үедээ зөвхөн өөрийн бодит байдлын зорилгын улмаас л сүсэлж байгаа хэрэг. Хүний дотоод хоосон байдал нь ямар нэг оромж хайхыг хүсээд байгаа учраас л тэр сүм хийд, шашинд ханддаг. Хүний өөрөө өөрөөсөө тусгаарлагдсан байдал, өөртөө болон бусдад санаа тавихгүй байгаа байдал нь шашны гол аюул юм хэмээн Фромм үздэг.

Үүнээс гадна нэг чухал зүйл бол шинжлэх ухааны хөгжил дэвшил нь шашны шинжлэх ухаан-ид шидийн бүрдэл хэсэгт нөлөөлж буй байдал юм хэмээн Фромм үздэг. Хүн байгалийг төдийлөн танин мэдэж чадаагүй байх үед хүний сэтгэлгээнд шашны шинжлэх ухаан-ид шидийн бүрдэл хэсэг гол байр суурийг эзэлдэг байлаа. Хүн оддын хөдөлгөөн, мод ургах байдал, үер ус, газар хөдлөлтийн цаад шалтгааныг бурхан, далдын хүч, лус савдагтай холбон тайлбарладаг. Хүн байгалийг гүн гүнзгий танин мэдэх тусам байгалийг ид шидээр зохицуулах, шинжлэх ухааны тайлбар хийх үүргээ шашин алдсаар байдаг. Хэрэв хүн төрөлхтөн бүхнийг тэжээх чадвартай юм бол хүн талхны төлөө мөргөн сүслэх шаардлагагүй болж байна. Өрнийн шашин шашны дээрх талыг өөрийн тогтолцооны нэг салшгүй хэсэг гэж үзээд шинжлэх ухааны мэдлэгийн дэвшилтэт хөгжилд өөрийгөө эсрэгцүүлэн тавьсан байдаг бол дорнын шашин нь хүнтэй холбоотой шашны тал, байгалийг тайлбарлах шашны талыг тус тусд нь ялгадаг. Тухайлбал, өрнийн шашинд ертөнц төгсгөлөг шинжтэй юу эсвэл мөнх үү гэсэн асуултанд байнга л маргаан үүсгэдэг. Буддизм болон индуизмд ертөнцийн тухай асуудал жаахан егөөдөл маягтай хэмээн Фромм үзжээ. Буддагаас энэ тухай асуухад тэрээр “мэдэхгүй, мэдэхийг хүсэхгүй байна, учир нь үүнд ямар ч байдлаар хариулсан хүний зовлонг яаж хөнгөвчлөх вэ гэсэн цорын ганц чухал асуултанд хариулт өгч чадахгүй” хэмээн хариулдаг. Дорнын шашинд шинжлэх ухаан-ид шидийн тал нь хүнийг танин мэдэхүйн талаас ялгаатай болох нь харагдаж байна.

Шашны дараагийн нэг чухал бүрдэл хэсэг нь зан үйл болох тухай Фромм онцолдог. Сэтгэц задлан шинжээчид зан үйлд онцгой анхаарал тавьдаг байна. Тодорхой хэв маягийн өвчтөнүүд гадаад байдлаараа шашны хэлбэрийг санагдуулахуйц хувийн зан үйл гүйцэтгэдэг. Сэтгэц задлан шинжлэлийн судалгааны хувьд шаардлагатай зан үйл нь хүчтэй сэтгэл хөдлөлийн үр дүн байдаг бөгөөд энэхүү сэтгэл хөдлөлийг өвчтөн зан үйлийн тусламжтайгаар үл ухамсарлах байдлаар даван туулдаг. Сэтгэц задлан шинжлэх эмчилгээний үеэр тухайлбал угаалгын зан үйлд өвчтөн ямар нэг бодьтой үйл хөдлөлөөр бус, харин үл ухамсарлах, арилган-устгах үүрэг бүхий импульсын тусламжтайгаар буруутай гэх гүнзгий мэдрэмжээсээ салах оролдлогыг хийдэг. Сэтгэц задлан шинжээчид албадлагын байдалд буй өвчтөний хийдэг тийм зан үйлийн механизм нь шашны зан үйлийн механизмтай адил хэмээн үздэг бөгөөд зан үйлд шууд ба шууд бус байдлаар илрэх бурхнаар төсөөлөгдөж байсан аавынхаа дууриамал хэлбэр дүрсийг үзэн ядаж устган хаях гэх мэт өвчтөний үл ухамсарлах сонирхлыг эрж хайхыг эрмэлздэг байна.

- Гэвч сэтгэц задлан шинжээчдийн зан үйл зөвхөн иррациональ шинжтэй байх тухай үзэл санаан дээр санал нийлэхгүй байгаагаа Фромм илэрхийлээд шашны рациональ ба рациональ бус зан үйлийг ялгах шаардлагатай хэмээн үзжээ. Бидэнд оршихуйн утга учрыг өгч байдаг зүг чигийн тогтолцоо хэрэгтэй байдаг төдийгүй нийтлэг үйл байдлаар олж авсан үнэлэмжийн чиг баримжаагаа

илтгэн харуулах шаардлага тулгардаг. Ер нь бол зан үйл нь олон нийтийг хамарсан нийтлэг үнэлэмжийн үндэс болдог нийтлэг хүсэл зоригийг илэрхийлэх нийтлэг үйл ажиллагаа юм. Рациональ зан үйл нь иррациональ зан үйлээс юуны өмнө үүргээрээ ялгаатай. Рациональ зан үйл нь дарамтын импульсыг өөртөө агуулдаггүй, харин хувь хүний үнэ цэнэтэй гэсэн хүсэл зоригийг илэрхийлдэг. Тиймээс рациональ зан үйл нь дарамталсан зайлшгүй зан үйлийн шинжийг агуулдаггүй. Харин иррациональ зан үйлийг ядаж нэг удаа л хийгээгүй тохиолдолд дарамт гэнэт гадагшилж болох ба ямар нэг алдаа гарах л юм бол тайван бус байдлыг төрүүлж болно. Рациональ зан үйлийг гүйцэтгэх үед алдаа нь ямар ч үр дагавар учруулдаггүй бөгөөд ийм зан үйлийг гүйцэтгээгүй тохиолдолд харамсаж болох боловч түүнээс айх хэрэггүй байдаг. Орчин үеийн рациональ зан үйлийн энгийн жишээ бол бие биетэйгээ мэндлэх зуршил, жүжигчдийг алга ташилтаар шагнах, үхэгсдэд хүндлэлтэй хандах гэх мэт болно. Мацаг барих, шашны гэрлэх ёслол, бясалгал хийх зэрэг нь рациональ шинжтэй бөгөөд утга санааг нь ойлгон шинжлэхүйгээс өөр онцын шинжилгээ шаардахгүй. Сэтгэц задаргааны онол нь зан үйл хийх шаардлагын сэтгэл зүйн үндсийг нээсэн бөгөөд үүгээрээ зан үйл судлалд томоохон хувь нэмэр оруулсан гэж Э.Фромм үздэг.

Фроммын үзлээр орчин үеийн ардчилсан нийгэм, соёлын амьдралд зан үйл олон байдаг ба зан үйлийн практик дээр янз бүрийн хэлбэр байгааг гайхах хэрэггүй. Тухайлбал, худал ярих, улс орноо эх оронч үзлээр хүндлэхтэй холбоотой зан үйл, найрсаг харилцааны зан үйл гэх мэт нь шашин ба ёс зүйгээр албан ёсоор хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлсээс салах, тэдэнд үйлчлэх зорилго ховордсоны шинж тэмдэг юм. Зан үйлийн хэрэгцээ шаардлага нь хэдийгээр маргашгүй зүйл боловч энэ хэрэгцээг бүрэн гүйцэд ухаарч ойлгодоггүй нь энэ нийгэмд харагддаг. Бүх зүйл бидний өмнө хоёр л боломж байгаа мэт санагдуулдаг. Үүнд, эсвэл бид шашны хүн болж утга учиргүй зан үйлийг гүйцэтгэх, эсвэл бид энэ зан үйл гүйцэтгэх хэрэгцээгээ хангахгүйгээр амьдрах. Хэрэв зан үйлийг бүтээх нь энгийн хэрэг байсан бол бид шинэ хүмүүнлэг зан үйлийг бүтээх байсансан. Гэвч зан үйл нь үйлдвэрлэлийн эд зүйлстэй адил биш юм. Зан үйл нь жинхэнэ нийтлэг үнэлэмж байгаа эсэхээс шалтгаалдаг бөгөөд ямар хэмжээнд үнэлэмж нь үүсэн бий болж, бодит байдлын хэсэг болж байгаагаас шалтгаалан бид томоохон рациональ зан үйлийн илрэлийг ажиглаж болно /6/.

Шашны дараагийн чухал бүрдэл хэсэг нь, Э.Фроммын үзлээр, семантик буюу бэлгэ тэмдгэн хэл юм. Шашин өөрийн сургаал номлол, зан үйлдээ бидний өдөр дутмын хэлнээс онцгой ялгарах бэлгэ тэмдгэн хэлээр ярьдаг. Бэлгэ тэмдгэн хэл бол бүхий л хүн төрөлхтөн мэддэг цорын ганц нийтлэг хэл юм. Үүнд эртний шид домгуудын хэл, орчин үеийнхний зүүдний хэл зэрэг багтана. Фрейд

энэ мартсан хэлийг бидэнд сануулж бэлгэ тэмдгэн хэлний онцлогийг ойлгох арга замыг нээж, түүний бүтэц утгыг тайлбарласан⁵⁰ хэмээн Фромм үзсэн байна.

Ийнхүү Фромм шашинд ямар асуудал байгааг судлах нь шашны чухам ямар бүрдэл хэсгийг хөндөж байгаагаас шалтгаална гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Түүний үзлээр бурхны тухай асуудал нь шашны асуудал болохынхоо хувьд юун түрүүнд хүний асуудал болохыг онцолсон байна. Шашны томъёолол болон бэлгэ тэмдэг нь хүний туршлагын тодорхой хэлбэрийг илэрхийлэх оролдлого юм. Энд хүний туршлагын мөн чанар чухал байна. Бэлгэ тэмдгийн тогтолцоо нь хүний жинхэнэ бодит байдлыг дүгнэх дохио юм. Фромм дүгнэхдээ соён гэгээрлийн үеэс хойш шашны судалгаа нь хүний тодорхой тогтолцоонд бус, харин бурханд итгэх итгэлийг няцаах эсвэл дэмжихэд л гол анхаарлаа төвлөрүүлсээр ирсэн гэжээ. Бурхны ном түгээгчид өөрийн мөн чанарынхаа хувьд үл итгэгчид байж болох ба харин бурханд үл итгэгчид хүн төрөлхтний сайн сайхны төлөө, хайр энэрэхүйд өөрийгөө зориулж итгэл үнэмшил, жинхэнэ шашинлаг шинжийг олж авч болох юм. "Бурхан" хэмээх бэлгэ тэмдгийг үгүйсгэх эсвэл батлахад анхаарах нь шашны асуудлыг хүний асуудал гэж үзэх ойлголтонд саад болдог бөгөөд хүмүүнлэг утгаараа ертөнцөд хандах хүний шашны хандлагын хөгжлийг удаашруулж байна гэсэн дүгнэлтэнд Фромм хүрчээ. Бурханд итгэх итгэл, үл итгэл хоорондын зөрчил байгаа юм биш, харин хүмүүнлэг шашны тогтолцоо болон онгон шүтээн тахих хэлбэр (ухамсарт сэтгэлгээнд ямар байдлаар илрэхээс үл шалтгаална) хоорондын зөрчил бодьтой оршин байгаа юм. Христосын ба еврейн теологийн хөгжилд бурхны тухай ямар нэг тодорхойлолтоос зайлсхийж цэвэр ойлголтонд хүрэх оролдлогууд (Плотин, Маймонид) хийгдэж байсан байна. Германы томоохон мистик болох Майстер Экхартын үзлээр "бурхан гэж нэрлэж байгаа зүйл бол бурхан биш, бурхан гэж нэрлээгүй зүйл нь нэрлэснээсээ илүү бурхан байдаг". Шашныг үл тэвчих нь сэтгэл судлалын байр сууринаас хайр, итгэл үнэмшил үгүйгээс урган гардаг ба энэ нь шашны хөгжилд муу нөлөө үзүүлж, онгон шүтээнд сүсэглэх шинэ хэлбэрийг дагуулдаг. Бурхны дүр зургийг мод чулуунд бус, харин үгэнд бүтээх болжээ. Бурхан шүтээнд сүслэхийн мөн чанар нь тодорхой нэг зүйлийг сүслэх бус, харин хүний онцгой хандлагад оршиж байна. Энэ хандлага нь юмс болон утга санааны нарийн учрыг бурханчлах, эсвэл буруутгахад оршдог. Мөн хүний үүнээс огт өөр хандлага байх бөгөөд энэ хандлагад хүний амьдрал дээд зарчмуудыг биелүүлэхэд орших юм. Шүтээнүүд нь мод чулуу байхаас гадна үг, машин, төр, эрх мэдэл, улс төрийн бүлгэм байж болно. Шинжлэх ухаан, ойр дотны хүмүүсийн санаа бодол нь мөн шүтээн байж болох бөгөөд мөн бурхан ч гэсэн шүтээн юм. Бурхны тухай маргаанаа зогсоож

- шүтлэгийн орчин үеийн хэлбэрийг илрүүлэх үйл хэрэгт нэгдэх цаг ирсэн юм биш

⁵⁰ Бэлгэ тэмдгэн хэлний онцлогийг Фрейд төдийгүй бүтэц шинжлэлийн арга зүйг үндэслэгч К.Леви-Стросс шид домгийн хэлээр дамжуулан маш тодорхой тайлбарласан. Энэ тухай Философи-Шашин судлал сэтгүүлийн XI дугаарын 77-р талд дурдсан болно.

үү хэмээн Фромм дүгнэсэн байна. Бид шашны хүмүүс мөн, биш эсэх, шинэ шашин эсвэл шашингүй шашинд итгэх хэрэгцээ шаардлага бидэнд байгаа эсэх нь бидний гадаад байдалд бус мөн чанартаа, үгэнд бус санаа сэтгэлдээ, сүм хийдэд бус хүндээ ямар хэмжээнд санаа тавьснаас шалтгаална. Бид ямар нэг өөрсдөөсөө гадна орших зүйлд шүтэн бишрэх мухар сүсгийг эрс үгүйсгэх дээр нэгдэж чадна. Ингэснээрээ бид илүү найрамдал, ахан дүүсийн хайрыг олж авч чадна /7/ хэмээн Эрих Фромм дүгнэжээ.

Фроммын шашны тухай үзэл санаа нь шашны хүмүүнлэг утгыг гаргаж, шашны тухай сонгодог онолыг шүүмжилсэн гэж бид үзэж байна. түүний үзлээр шашин бол маш энгийнээр ойлгож болох хүний өөрийнх нь хүч чадалд найдлага тавьдаг үйлдэл, сэтгэлгээний дурын тогтолцоо юм. Харин шашны тухай нэлээд сонгодог гэж үзэж болох тодорхойлолтыг XX зууны эхэн үеийн Английн хүн судлаач, шашин судлаач, Кембриджийн Их сургуулийн профессор Джеймс Джордж Фрээр "Алтан мөчир" хэмээх 12 боть зохиолдоо "Шашин гэдгийн дор хүнээс дээш оршин буй бөгөөд хүний амьдрал хийгээд байгалийн үзэгдлийн өрнөл явцыг чиглүүлж, хянаж байдаг хэмээх хүчнүүдийн өршөөл нигүүлсэл, илбэн тохинуулж, засан амирлуулах явдлыг ойлгож байна /8/" гэсэн байна. Фромм хэдийгээр ёс суртахууны ба шашны гэх хоёр ойлголтыг ялгахыг зорьсон ч шашны гэх шинжийг онцолсон бөгөөд шашны ухамсрын онцлогийг ертөнцөд хандах хүний хандлагын тайлагдашгүй нууц, амьдралын ухаарал, гайхах мэдрэмж болно гэж үздэг. Харин Фрээр шашны ба ёс суртахууны хэмээх хоёр ойлголтыг ялган үздэг. Үүнд, "Хоёр хүн яг адил байдлаар биеэ авч явж болох ч, нэг нь шашин сүсэгтэй, нөгөө нь үгүй байж болно. Хэрвээ хүн бурханд хандаж хайр энэрэл, эсвэл түүнээс айх айдаст тулгуурлан үйлдэл хийж (амьдарч) байвал, тэрбээр сүсэг бишрэлтэй хүн юм. Хэрвээ тэрбээр хүнийг хайрлах хайр, эсвэл түүнээс айх айдсанд үндэслэн үйл хөдлөл хийж буй бол түүний авир үйлдэл нь нийтийн сайн сайхан, буянтай тохирч байна уу, зөрчилдөж байна уу гэдгээс хамааран ёс суртахуунтай, буюу ёс суртахуунгүй хүн болж байдаг /8/". Фрээр ёс суртахууныг сүсэг бишрэлтэй адилтган үзээгүй нь харагдаж байна. Харин Фромм шашны ёс суртахуунаас ялгарах нэгэн чухал онцлог нь ертөнцөд хандах хүний хандлагын тайлагдашгүй нууц, амьдралын ухаарал, гайхах мэдрэмж болно гэсэн байна.

Фромм шашны үнэн зөвийг шүүх оролдлого хийсэнгүй, харин хүмүүсийн шашныг ойлгох ойлголтыг шүүмжилсэн. Түүний үзлээр шашин бол албадлагын шинж чанартай бус, хүнд жинхэнэ эрх чөлөөгөө мэдрэх боломжийг олгодог хайрлах мэдрэмжтэй хүний сэтгэлийн тайван байдал юм. Энд шашны сэтгэл зүйн үүргийг онцолж байгаа хэдий ч сонгодог сэтгэл зүйд авч үздэг сэтгэл хэмээх ойлголтыг бус, хайрлах мэдрэмж хэмээх феноменд онцгой анхаарал хандуулсан гэж хэлэхэд болно. Сонгодог философийн үүд хаалгыг хааж сонгодог бус, орчин үеийн философийн судлах зүйлийг нээлттэй орхисон XIX зууны Германы философич И.Кант хүний чухал гурван чадварын боломжийн

хязгаарыг тогтоодог. Үүнд, хүний танин мэдэхүйн чадвар, ёс суртахууны чадвар, үнэлэмжийн чадвар багтана. Кант хүний тухай сонгодог онолыг системчилж, сонгодог бус онол төрөх үүд хаалгыг нээж өгсөн учир нь тэрээр хүний мэдрэмжийн чадварын боломжийн хязгаарыг хүн судлалын бүхий л шинжлэх ухааны өмнө асуудал болгон орхисон. Хүн танин мэдэхүй, ёс суртахуун, гоо сайхны чадвартайгаас гадна маш чухал чадвар болох хайрлах онцгой мэдрэмжтэй буюу феноментэй оршихуй юм. Хүний мэдрэмж энгийн бие мах бодийн 5 мэдрэхүйгээс гадна дотоод мэдрэмж хэмээх агуу чадвартай байдаг. Мэдрэмж гэдэг бол сонгодог сэтгэл судлалын үздэг шиг сэтгэл хөөрөл биш. Энэ бол рационалист талынхны үздэг шиг хүсэл тачаал төөрөгдөл бус, энэ бол хүний тогтворгүй шинж бус, энэ бол хайрлан энэрэх, бусдад болон өөртөө шударга, үнэнчээр хандах тийм онцгой мэдрэмж юм. Хүн энэхүү мэдрэмжээ яг л танин мэдэхүйгээ хэрхэн хөгжүүлдэг шиг байнга хөгжүүлж байх хэрэгтэй юм гэсэн санаа Фроммын үзэл санаанд харагддаг. Хүн хайрлах мэдрэмжээ хөгжүүлэхэд тус нэмэр болох үүргийг хүмүүнлэг шашин хариуцаж болно гэсэн санааг Фромм дэвшүүлжээ. Хүмүүнлэг шашны гол зорилго бол хүний аливаад хандах шашны ухамсарыг сэргээн төлөвшүүлэхэд оршино. Сэтгэц задлан шинжлэх онол нь хүмүүнлэг шашны адилаар сэтгэцийн өвчтөнийг төдийгүй энгийн зохицолт хүнийг ч энэ л мэдрэмжээ хөгжүүлэх боломж байгааг харуулдаг. Фроммын үзлээр хүн бурхан, шашинд итгэх итгэлрүүгээ эргэн очиход бус, харин хүн үнэнээр сэтгэж, хайраар амьдарч чадаж байна уу гэдэг нь чухал юм. Шашинг харанхуй, бүдүүлгийн илрэл хэмээн үзэж болохгүй. Шашин бол сул арчаагүй байдлын бэлгэ тэмдэг бус, хүний хамгийн нандин чанар болох хайрлах мэдрэмжээ хөгжүүлэх арга юм.

SUMMARY

Erich Seligmann Fromm (1900 – 1980) was a German-American Jewish social psychologist, psychoanalyst, humanistic philosopher, democratic socialist, neofreudist. He was associated with what became known as the Frankfurt School of critical theory.

Psychology of religion plays a big role in modern theory of religion. In this article we tried to explain Fromm's main idea about religion. We found this idea in Fromm's work "Psychoanalysis and Religion", which was translated to Russian in the work "Сумерки богов". Problem of religion's perspective is not just problem of national culture, it is problem of the World's culture. If different religion didn't find relationship, conflict between religions would cause big problem, for example cultural war. If religions found relationship, a lot of cultures would be removed. Because religion is headstone of culture.

Fromm was fascinated by the psychological aspects of religion and what seemed to be a ubiquitous need for religion by humans. According to Fromm's idea religion is any kind of Human's act and thought, which can give thing of fair living and chance of life to the fullest. In discerning the positive and negative effects of religion on individuals, Fromm drew a distinction between authoritarian and humanistic religions. Authoritarian religious entities promulgate the belief that humans are at the mercy of an omnipotent God, whereas humanistic ones promote the belief that the power of God is visible in the mane of the individual. According to Fromm, authoritarian religions disserve the individual by denying their individual identities, while humanistic ones provide for personal validation and growth.

In discerning the positive and negative effects of religion on individuals, Fromm drew a distinction between authoritarian and humanistic religions. Authoritarian religious entities promulgate the belief that humans are at the mercy of an omnipotent God, whereas humanistic ones promote the belief that the power of God is visible in the mane of the individual. According to Fromm, authoritarian

religions disserve the individual by denying their individual identities, while humanistic ones provide for personal validation and growth. Also he divided four side of religion: thought wish, science-magic, ritual, semiological side or symbol language.

Fromm doesn't try to consider the truth or untrue of religion, he denominates that it is important for people to have religion's right tendency, conscience, mind which helps people out develop feeling ability to love and intellect without faith in high power God's ability.

Ишлэл авсан бүтээлүүд

1. Э.Фромм. Психоанализ и религия //Сумерки богов. М.,1989. С.84.
2. Мөн тэнд. 105 дахь тал.
3. Мөн тэнд. 108 дахь тал.
4. Мөн тэнд. 110 дахь тал.
5. Мөн тэнд 115 дахь тал.
6. Мөн тэнд 120 дахь тал.
7. Мөн тэнд 123 дахь тал.
8. Д. Д. Фрэзер. Золотая ветвь: Исследование магии и религии. М., 1998.
9. Новая философская энциклопедия: в 4 т. / Ин-т философии РАН; Нац. обществ.-науч. фонд; Предс. научно-ред. совета В. С. Степин. - М.: Мысль, 2000 - 2001. Электрон эх сурвалж.
1. <http://iph.ras.ru/elib/0025.html>